

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	МЦХ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал		
Огноо:	2018 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр 11:00-13:00	Уулзалтын газар:	Компанийн хурлын заал
Хурлын дарга:	Чулуунбатын Пүрэвсүрэн, МЦХ ХК-ийн Стратеги төлөвлөлтийн газрын дарга		
Тооллогын комисс:	Тооллогын комиссын дарга Д.Ганцэцэг, МЦХ ХК-ийн Дотоод аудит, шинжилгээ үнэлгээний албаны мэргэжилтэн Гишүүд: Б.Ариунгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын ахлах мэргэжилтэн О.Содбаяр, Хүний нөөцийн албаны мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Зохион байгуулах комиссын дарга Д.Болдбаатар, МЦХ ХК-ийн Удирдлага, хүний нөөцийн газрын дарга Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Удирдлага, хүний нөөцийн газрын хуулийн ахлах мэргэжилтэн		
Оролцсон хувьцаа эзэмшигчид	Д.Мөнхтөр	Хувьцааны тоо 88 ширхэг	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276.0 ширхэг. Үүнээс нийт 24,500,933 ширхэг саналын эрх бүхий 14 хувьцаа эзэмшигч оролцсон.
	С.Жамбал	Хувьцааны тоо 210 ширхэг	
	Т.Эх-Оюун	Хувьцааны тоо 81 ширхэг	
	Д.Доржсүрэн	Хувьцааны тоо 245 ширхэг	
	Д.Эрвэгилхам	Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, хувьцааны тоо 24,499,287 ширхэг	
	Д.Энхтуяа	Хувьцааны тоо 2 ширхэг	
	М.Баяраа	Хувьцааны тоо 280 ширхэг	
	Б.Ганболд	Хувьцааны тоо 1 ширхэг	
	М.Алтан-Очир	Хувьцааны тоо 210 ширхэг	
	Б.Бямбасүрэн	Хувьцааны тоо 79 ширхэг	
	Б.Цэрэнбадам	Хувьцааны тоо 280 ширхэг	
	С.Дамдинсүрэн	Хувьцааны тоо 70 ширхэг	
	Ж.Энхтунгалаг	Хувьцааны тоо 100 ширхэг	
Ирц:	94.71%		

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг батлах тухай
2. Орон сууц хувьчлах тухай

СОНССОН нь:

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: Ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас 24,500,933 ширхэг хувьцаа эзэмшиж буй 14 хувьцаа эзэмшигч ирж 94.71 хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: МЦХ ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэгийг танилцуулж хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг танилцуулав.

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: Орон сууц хувьчлах тухай асуудлыг танилцуулав.

Санал, асуулт хариулт:

Д.Энхтуяа, хувьцаа эзэмшигч: Компанийн дүрмийн 4.4.3 дээр хувьцаа эзэмшигчдийн эрхийг ямар үед хязгаарладаг юм бэ?

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Хэрвээ ХЭ-ийн эрхийг хязгаарласан эсвэл компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах эсвэл нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хүлээн зөвшөөрөөгүй энэ асуудалд хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигч эрхээ хязгаарлуулсан гэж үзвэл ХЭ компанид хувьцаагаа худалдах саналаа гаргах эрхтэй. Өнөөдөр танилцуулсан МЦХ ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд ХЭ-ийн эрхийг хязгаарласан заалт ороогүй. Тэгэхээр энэ заалтаар таны эрхийг хязгаарласан гэсэн ямар нэг заалт зохицуулалт энэ дүрмийн төсөлд ороогүй байгаа.

Б.Ганболд хувьцаа эзэмшигч: 1.) 7.18 дээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох гэж байгаа. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэж байх хэрэгтэй юу уу, үгүй юу? Нэрийг нь заагаад өгчихлөөр сонгууль болоод баахан байгууллага татан буугддаг, өөрчлөгддөг, одоо байгаа байгууллага дахин хэдэн жил явах уу үгүй юу, хэрэв энэ байгууллага байхгүй болчихвол дахиад дүрэмдээ өөрчлөлт оруулах уу. 2.) Эрх бүхий албан тушаалтан гэдэгт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга байхгүй байна. КТ хуулиар энэ бол эрх бүхий албан тушаалтанд байдаг шүү дээ.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн төлөөлөх этгээдийн томилох, чөлөөлөх эрх нь ТӨБЗГ-т байна. ТУЗ-ийн төрийн өмчийн төлөөллийг томилох, чөлөөлөх эрх нь нэг талаасаа Компанийн тухай хуульд байгаа боловч Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлд ТУЗ-ийн төрийн өмчийг төлөөлөгч гишүүдийг сонгох эсэх асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна гэж заасан. Тиймээс зайлшгүй ТУЗ-ийн төрийн төлөөллийн 6 гишүүнийг томилох асуудлыг оруулж өгөх шаардлагатай.

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэж орсон байгаа учраас ямар нэг нэр өөрчлөгдөхөд энэ бодлогыг хариуцсан төрийн захиргааны байгууллага л цаашид явах учраас ямар нэг асуудал үүсэхгүй.

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Энэ асуудал ТУЗ дээр яригдсан зохих хувилбарын дагуу ингэж орох нь зүйтэй гэж үзсэн.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: 2 дугаар асуултын хувьд хуульд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн эрх бүхий албан тушаалтан байхаар заасан, тэгэхээр тэр дээр магадгүй редакцын өөрчлөлт хийгээд нэмж оруулах боломжтой болов уу. Хурал даргалагч шийдвэрээ гаргах байх.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Дүрмийн өөрчлөлтийн талаар ор тас хассан заалт байна уу үгүй юу?

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Гүйцэтгэх захирлын хэсэгт ТУЗ-ийн даргаас бусад ТУЗ-ийн гишүүнээс гүйцэтгэх захирлаар томилогдож болох заалт өнөөдрийн мөрдөгдөж байгаа дүрэмд байгаа. Үүнийг ТУЗ-ийн гишүүдийн саналаар хассан.

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: 1.10 заалтад “Энэ дүрмийг монгол англи хэл дээр үйлдсэн бөгөөд тэдгээр нь адил хүчинтэй байна. Хэрвээ дүрмийн аливаа заалтыг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрх эхийг үндэслэх болно.” гэсэн заалтыг хассан байгаа. 7.30 дугаар заалт “ТУЗ-ийн даргаас бусад ТУЗ-ийн гишүүнээс гүйцэтгэх захирлаар томилогдож болно” гээд энэ заалтыг хассан байгаа.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Хассан заалтыг оруулаад дээр нь дараад оруулсан бол илүү ойлгомжтой болох байлаа гэж хэлэх гэсэн юм.

Би буруу харж байж магадгүй. 7.19.12 заалтыг хассан юм шиг байна. Үүнийг ач холбогдолгүй гэж үзээд хассан байж магадгүй. Эсрэг байх магадлалтай гэрээ байхгүй байх юм байна гэж ойлголоо.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Тэр заалтыг хуульд заасан учраас ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн. Хуульд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл гээд Компанийн тухай хуулийн 82, 83 дугаар зүйлд тодорхой зохицуулсан. Их хэмжээний хэлцэл гэж ямар хэлцлийг хэлэх вэ? Түүнийг ТУЗ болон ХЭХ ямар эрхтэйгээр оролцох вэ гээд өөрчилсөн тул ТУЗ-ийн хурал дээр хасья гээд хасагдсан.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Компанийн тухай хуульд заасан тул энд байх хэрэггүй гэж үзсэн гэж ойлгож болох уу?

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Тийм ээ, ТУЗ тэгж үзсэн байгаа.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: Орон сууцанд дээрээс нэг зүйл асууя. Нарантуяа гэдэг хүний эзэмшиж байгаа орон сууц 1985 онд ашиглалтад орсон байна. Тэгэхээр ашиглалтад орсон хугацаанаас нь хойш элэгдэл хорогдлыг нь тооцсон байна уу, манайд анх шилжиж ирсэн хугацаанаас нь хойш тооцсон байна уу?

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: Манайд анх 2003 онд худалдаж авсан. Тэр 2003 оноос нь элэгдэл хорогдлыг нь тооцсон байгаа.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: 2003 оноос өнөөдрийг хүртэл 15 жил болсон. Компанийн мөрдөгдөж байгаа журмын дагуу орон сууцны хуримтлагдсан элэгдэлийг хорогдлыг хэдэн жилээр тооцдог вэ?

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: 60 жил

Д.Болдбаатар, УХНГ-ын дарга: Тэгвэл нэг жилд хэдэн хувь гэсэн үг вэ?

Ч.Пүрэвсүрэн хурлын дарга: 1.67 хувь.

Д.Доржсүрэн, хувьцаа эзэмшигч: 3,48 сая төгрөг хэдэн хувиар бодогдоод байна. Анх ашиглалтанд орсон хугацаанаас нь тооцдоггүй юм уу?

Т.Эх-Оюун, МЦХ ХК, СХОГ-ын дарга: Манайд анх худалдаж авсан өдрөөс элэгдэл нь тооцогдох ёстой. 1985 онд хэн нэгэн хүний эзэмшилд элэгдэл нь тооцогдоол явж байсан байх. Манайх өөрөө худалдаж авсан өдрөөсөө эхлээд элэгдэл нь тооцогдоод явсан. Хуулиараа тийм. Манай байгууллага өөрсдөө тогтоож болно л доо. Энэ барилга нь 1985 онд ашиглалтанд орсон байсан. Иймд 60 жилээр биш 40 жилээр юм уу 30 жилээр элэгдэл тооцно гэж тогтоож болно.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: 1.) 7.12 дээр Компанийн саналын эрх бүхий хувьцааны 61 ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч орсноор ХЭХ хүчин төгөлдөр байна. Хуучин КТ байхад ингэж байсан. Яагаад энэ 61 гэсэн тоон дээр өөрчлөлт орохгүй байсан юм бэ? 2.) 7.14 дээр 10 аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь өөрөө хүсвэл эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох эрхтэй. Энэ заалт байх шаардлагатай юу? 3.) 7.22 дээр Чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүнийг сонгох хүртэл түүнийг орлох этгээдийг орлох этгээдийн нөхөн сонгууль хүртэл ТУЗ-өөс түр томилж болно. Энэ хуульд нийцэж байгаа юу? 4.) 7.29.1 дээр зах зээлийн үнэлгээгээр 300.0 ам.доллараас доош ... гээд энэ заалтууд хасагдсан байсан. Яагаад гараад ирсэн юм бэ? Энэ хэвлэлийн алдаа юу уу эсвэл зүгээр үү?

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: 7.29.1 дэх заалт хасагдаагүй.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: ТУЗ-ийн хурлаар хасагдсан байна шүү дээ.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Тэр бол зөвхөн ТУЗ-тай холбоотой хэсэг дээр хасагдсан.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Ажлын хэсэг ажилласан, ТУЗ-ийн гишүүдээс өгсөн саналыг харьцуулаад харахад хасагдсан юм биш үү.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Тэр бол энэ дээр адилхан 300.0 ам.доллараас дээш бол гэсэн асуудал ТУЗ-ийн бүрэн эрхийн асуудал дээр байсан. Тэр хэсгүүд хасагдсан. Гүйцэтгэх удирдлагатай холбоотой заалтууд бол зөвхөн одоогийн мөрдөгдөж буй дүрмийн 7.30 дээр заасан ТУЗ-ийн даргаас бусад гишүүдээс Гүйцэтгэх захирлыг сонгож болно. гэсэн заалт хасагдсан. Бусдаар 7.29.1, 7.30 гэсэн хоёр заалт байгаа.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Тэр бол ТУЗ-ийн санал, энэ бол ХЭХ-ын санал тийм үү.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Тийм.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Шууд саналаа хэлье.

- Одоо бол ихэнх хувийг төр эзэмшиж байгаа. Төрийн өмчит компаниудын дүрмийг батлаад явж байгаа. Ихэнх төрийн өмчийн хувьцаат компаниудын дүрмийг ХЭХ-аас баталдаг. Компанийн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал дутуу санагдсан. Энэ дээр нэмж тусгах бизнес төлөвлөгөө, компанийн зорилтот түвшин эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг хаанаас батлах вэ? Тодорхойгүй байна лээ. ТУЗ батлах байх;

- ТУЗ-ийн хурлыг жилд 4 өөс доошгүй удаа хуралдуулна гэж хуульд компани дүрмэндээ өөрөөр заагаагүй бол сар бүр хуралдана гэсэн байгаа. ТУЗ-ийн хурлыг ойрхон хуралдуулах саналтай байна. Сар бүр хуралдах, ТУЗ-өөс хэлэлцсэн, ажлын хэсгээс хэлэлцсэн дээр тодорхой заагдаагүй байсан. Энэ дээр тодруулж, тодорхой зааж өгөөч ээ.

- ХЭХ-аар хэлэлцэх асуудал дээр ч гэсэн яг гол үзүүлэлтүүдийг нь батлах юм уу үгүй юм уу, ХЭХ-ийн хэлэлцэх асуудал дээр байхгүй байна. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, ХЭХ-аар хэлэлцэх асуудлыг нэмж тодорхой болгох саналтай байна.

- Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулагдана. Энэ гэрээн дээр захирлын эрх хэмжээ, гэрээ хэлцэл байгуулах, үндсэн хөрөнгийг захиран зарцуулах эрх хэмжээг бүгд тусгадаг учраас дүрэм дээр түрүүнд миний асуусан заалт шаардлагагүй гэж үзэж байна. 300 ам.доллар гээд гадны хөрөнгө оруулалттай байсан учраас тухай үед америк доллараар тусгасан байсан. Одоо төгрөгөөр хийгдэж байгаа. 7.29.1 дэх заалт байх шаардлагагүй байх гэсэн саналтай байна.

- 7.22. дээр ТУЗ-өөс түр томилж болно гээд ТУЗ ТУЗ-ийн гишүүнийг сонгоно гэж байх уу, үүнийг одоо өөрчлөх шаардлагатай юм биш үү.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: 7.22. дах асуудлыг Компанийн тухай хуулийн 77.5 дах заалттай нийлцүүлээд Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно гэсэн агуулгатай нийцүүлээд энэ бол зөвхөн түр хугацаагаар ТУЗ-өөс томилж болохоор энэ хуулийн зарчимд нийцүүлээд оруулсан.

Б.Ганболд хувьцаа эзэмшигч: Түр томилогдож байгаа хүн маань хараат бус гишүүний шаардлагыг хангасан байх ёстой гэсэн хуулийн заалтыг дүрэм дээрээ зааж өгөх ёстой юм биш үү.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Төрийг төлөөлж байгаа тохиолдолд төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагаас томилно.

Б.Ганболд хувьцаа эзэмшигч: Түр томилж байгаа бол тэр хүн хараат бус гишүүний шаардлага хангасан байх ёстой. Гэсэн заалт байгаа шүү дээ.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Тийм, эсрэг талаараа Төрийн болон орон нутгийг өмчийн тухай хуульд заасан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагын эрхийг хязгаарлах вий дээ гэсэн. Яагаад гэвэл төрийн төлөөлөл бол заавал хараат бус гишүүний шаардлага хангасан байна гэхээсээ илүү хуульд тусгайлан заасан тодорхой шаардлагуудыг хангасан этгээдийг томилж байгаа.

Б.Ганболд хувьцаа эзэмшигч: Энэ хоёр хуулийн аль нь дээр, доор орох ёстой вэ.

Ж.Азбаяр, МЦХ ХК-ийн УХНГ-ын хуулийн ахлах мэргэжилтэн: Компанийн тухай хуулийн 2.4 дэх хэсэгт төрийн өмчийн оролцоотой компанийн ТУЗ-ийн гишүүнийг томилохтой холбоотой асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна гээд заасан. Тийм учраас зөвхөн ТУЗ-ийн гишүүний томилох асуудлыг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллага Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрхээ эдлээд явахаас өөр аргагүй байгаа.

Д.Энхтуяа, хувьцаа эзэмшигч: Би 2014 оноос танай хувьцаа эзэмшигчдийн хуралд суусан. Жилээс жилд танай хурлын үйл ажиллагаа боловсруулж байгаа зүйл харьцангуй гайгүй хууль, тогтоомжийн дагуу их аятайхан болж байна. Эхлээд хурлаа удирдах, хийж байгаа үйл ажиллагаа ямар байсныг манай хувьцаа эзэмшигчид мэдэж байгаа байх. МУЗГ мэдэлдээ авсан 94.7 хувьтай холбогдуулаад Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлт нийтэд нь базаад хэлэхэд сайн болсон гэж үзэж байна. Ерөнхийдөө бол аятайхан болсон байна гэж хэлье.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Орон сууц хувьчлан авч байгаа энэ хоёр хүн урьд нь өөрийнхөө нийгмийн асуудлыг компаниас шийдвэрлүүлж байсан уу?

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Шийдвэрлүүлж байгаагүй. Өргөдлөө өгөөд 8 жил болж байгаа. ХЭХ, ТУЗ-өөс шийдэхгүй, олон жил ажиллаж байгаа. Компаниас ямар нэг тэтгэмж, тусламж авч байгаагүй. Орон сууцны жагсаалтад бий, Үйлдвэрчний эвлэлээс дэмжсэн, бүх талын шаардлага хангасан. Ямар нэг байр, орон сууц худалдаж авсан тохиолдол байхгүй.

Д.Эрэвгийлхам Төрийн өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч: Ер компаниас биш ч гэсэн манай оронд явагдсан орон сууц хувьчлалын асуудлаар орон сууц хувьчилж авч байгаагүй юм уу?

М.Алтан-Очир, МЦХ ХК-ийн Гүйцэтгэх захирал: Тийм ээ, тэр талаар бид тодруулга авсан.

Дүрмийн төсөлд тусгах санал:

1. Хуулинд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн эрх бүхий албан тушаалтан байхаар заасан заалтыг компанийн дүрмийн төсөлд тусгах,
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудалд бизнес төлөвлөгөөг батлах талаар тодруулж тусгах.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 24,500,933 ширхэг хувьцаа эзэмшиж буй 14 хувьцаа эзэмшигч оролцсоноос 24,500,574 ширхэг хувьцаа эзэмшиж буй 12 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 12 саналын хуудас хүчинтэй, хүчингүй саналын хуудас байхгүй байна.

Саналын хуудсаар нийт 2 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр дараах санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг батлах тухай

Зөвшөөрсөн 24,500,574 ширхэг хувьцаа буюу 100 хувь
Татгалзсан байхгүй

Түдгэлзсэн байхгүй

2. Орон сууц хувьчлах тухай

Зөвшөөрсөн 24,500,574 ширхэг хувьцаа буюу 100 хувь

Татгалзсан байхгүй

Түдгэлзсэн байхгүй

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар баталж,
 - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хавсралт ёсоор батлав.
 - Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийг зохих журмын дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (М.Алтан-Очир)-т даалгав.
 - Нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
2. Орон сууц хувьчлах тухай асуудлыг 100 хувийн саналаар баталж,
 - Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Y-2201007056 тоот улсын бүртгэлийн дугаартай, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 30 дугаар байр, 47 тоот хаягт байрлах 28 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцыг Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн Технологийн газрын Техникийн ашиглалт үйлчилгээний албаны ахлах инженер Д.Нарантуяад, Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгийн 3401496002 тоот бүртгэлтэй, Төв аймаг, Зуунмод сумын 1 дүгээр баг, 27 дугаар байр, 12 тоот хаягт байрлах 29 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцыг Төв аймгийн Холбооны газрын дарга Ц.Оюунчимэг нарт тус тус хувьчлан олгов.
 - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 17 дугаар хороо, 1 дүгээр хороолол, 30 дугаар байр, 47 тоот хаягт байрлах 28 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцны үлдэгдэл өртөг болох 11,256,538.27 төгрөгийг төлөхийг Д.Нарантуяад, Төв аймаг, Зуунмод сумын 1 дүгээр баг, 27 дугаар байр, 12 тоот хаягт байрлах 29 квадрат метр талбай бүхий 2 өрөө орон сууцны үлдэгдэл өртөг болох 3,077,407.23 төгрөгийг төлөхийг Ц.Оюунчимэгт тус тус даалгав.
 - Орон сууц хувьчлах, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг шилжүүлэх, компанийн үндсэн хөрөнгөөс хасах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Алтан-Очир)-т даалгав.

Танилцсан:

**Ч.Пүрэвсүрэн, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
бус хурлын дарга**

Тэмдэглэл хөтөлсөн:

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

2018 оны 11 дүгээр сарын 06
Улаанбаатар хот.